


Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх



# ШИРҮҮН ДОНСОЛГООНД ЗӨӨЛӨН ГАЗАРДАХ НЬ

Саяхан эхнэр Харриэт бид хоёр нисэх онгоцны буудалд асар том онгоцнуудын газардахыг харан зогссон юм. Энэ өдөр салхитай өдөр байсан бөгөөд салхи хүчтэй салхилж, нисэх онгоцыг хажуу тийш хазайлган, донсолгоо үүсгэж байлаа.

Биднийг байгаль дэлхий, машин техник хоёрын энэхүү тэмцлийг ажиглан харж байх үед нислэгийн сургалтад сурч, хожим нь бусад нисгэгчид зааж өгч байсан зарчим маань санаанд орлоо.

“Донсолгоотой үед хяналтаа бүү алд. Тайван бай; хэтэрхий хичээх хэрэггүй. Нислэгийн зурвасын төв шугамд л анхаарлаа хандуул. Хэрэв очих ёстой зурвасаасаа хазайсан бол зурвас руугаа хурдан орох хэрэгтэй. Нисэх онгоцныхоо бүхий л боломжинд найд. Донсолгоог даван туул” гэдэг байв.

Туршлагатай нисгэгчид эргэн тойронд нь болж буй бүх зүйлийг үргэлж хянаж чадахгүй гэдгээ мэддэг. Тэд донсолгоог зогсоож чадахгүй. Тэд бороо, цасыг үгүй болгож чадахгүй. Тэд салхийг зогсоож эсвэл чиглэлийг нь өөрчилж чадахгүй.

Харин тэд өөрсдийг нь сандарган хөшөөж буй донсолгоо, хүчит салхинаас айх нь алдаа гэдгийг мэддэг. Нөхцөл байдал ердийнхөөс өөр үед аюулгүй газардах арга нь зөвхөн өөрсдийн чиглэж буй зам дээрээ үлдэх явдал юм.

Би онгоцнууд ар араасаа ээлжлэн газардахыг харан зогсохдоо нисгэгч байсан он жилүүдэд суралцсан

зарчмаа санаж билээ. Үүнд бидний өдөр тутмын амьдралд зориулсан сургамж байгаа эсэхийг би мэдэхийг хүсэж байлаа.

Амьдралын бидний зам дээр тавьж буй тэрхүү салхийг бид үргэлж хянаж чадахгүй. Заримдаа юмс бидний санаснаар болдоггүй. Бид гомдол, эргэлзээ, айдас, гуниг болон сэтгэлийн хямралаас үүссэн донсолгоонд өртөж, тайван байдлаа алддаг.

Ийм үед болохгүй байгаа бүхэнд эзэмдүүлж, бодол санаагаа бэрхшээлд төвлөрүүлэх нь хялбар байдаг. Уруу таталт биднийг Аврагчид болон үнэний гэрчлэлдээ анхаарал хандуулахын оронд зөвхөн туулж буй зовлон бэрхшээлдээ анхаарал хандуулахад хүргэдэг.

Гэтэл энэ нь бидний амьдралд тохиолдож буй бэрхшээлийг даван туулах хамгийн сайн арга зам биш юм.

Туршлагатай нисгэгч салхинд бус нислэгийн зурвасын төв, онгоц газардуулах цэгтээ анхаарал хандуулдаг шиг бид ч мөн адил Аврагчид итгэх итгэл, Түүний сургаал, Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө болон тэнгэрлэг зурвастаа аюулгүй очих туйлын зорилгодоо төвлөрөх хэрэгтэй. Бид Бурханд итгэж, шавийн хийх ёстой зүйлд хичээл зүтгэлээ төвлөрүүлэх ёстой. Бид нүд, зүрх сэтгэл, бодол санаагаа өөрсдийн мэдэж буй дагах ёстой тэр замдаа төвлөрүүлэх хэрэгтэй.

Тэнгэрлэг Эцэгийн зарлигуудыг баяртайяа дагаснаар итгэл найдвараа Түүнд харуулах нь бидэнд аз жаргал,

алдар суут авчирдаг. Хэрэв бид өөрсдийн замд үлдэж чадвал ямар ч хүчтэй салхи, донсолгоог даван гарч, тэнгэрлэг гэртээ аюулгүй буцах болно.

Бидний эргэн тойронд тэнгэр цэлмэг эсвэл бүрхэг байхаас үл шалтгаалан Есүс Христийн дагалдагчийн хувьд бид эхлээд Түүний хаанчлал, зөв шударга байдлыг эрэлхийлснээр бусад бүх зүйл бидэнд нэмэгдэн өгөгдөхийг мэддэг билээ (Матай 6:33-ыг үзнэ үү).

Амьдралын ямар чухал сургамж вэ!

Бид бэрхшээл, тэмцэл, эргэлзээ, айдастаа автах тусам илүү хэцүү зүйлс ирдэг. Харин бид өөрсдийн туйлын зорилго болох тэнгэрлэг зурваст болон Бурханыг хайрлах, хөршдөө үйлчлэх зэрэг дагалдагчийн замаар явснаар ирэх баяр баясалд анхаарлаа төвлөрүүлснээр саад бэрхшээл тохиох бүрд үүнийг амжилттай даван гарах болно.

Эрхэм найз нөхөд минь, бидний мөнх бус энэ амьдралд ямар ч хүчтэй салхи салхилсан ч, Есүс Христийн сайн мэдээ үргэлж бидэнд Тэнгэрлэг Эцэгийн хаант улсад аюулгүй газардах хамгийн шилдэг замыг зааж өгдөг.

## ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф “Бурханд итгэж, шавийн хийх ёстой зүйлд хичээл зүтгэлээ төвлөрүүлэх хэрэгтэй” гэж зөвлөсөн. Зааж буй хүмүүсээсээ бэрхшээл тохиолдох үед тэд хэрхэн “туйлын зорилго болох тэнгэрлэг зурваст болон дагалдагчийн замаар явснаар ирэх баяр баясалд анхаарлаа төвлөрүүлсэн”-ийг асуу. Хэцүү зүйл тулгарах үед өөрсдийн гэрчлэлд болон Христэд анхаарал хандуулж болох арга замуудын тухай бодон, эдгээр санаанаас нэг эсвэл түүнээс илүүг хэрхэн амьдралдаа хэрэгжүүлж болохыг залбиран шийдэхэд тэднийг урьж болно.

## ЭСВӨР ҮЕИЙНХЭН

### Гэрчлэлийн маань үндэс суурь

Жэннифэр Вийвэр

Намайг 16 настай байхад нэг найз маань манай гэрт номлогчидтой хамт ирсэн юм. Эхний хичээлээ заалгаснаас хойш нэг сарын дотор надад байсан бүх асуулт тодорхой хариулагдсан билээ. Сэргээлтийн талаарх сайн мэдээний үнэнийг Ариун Сүнс надад гэрчилж байгааг би мэдэрсэн. Миний урьд нь мэдэрч байсан бүхнээс тэс өөр мэдрэмжийг би мэдэрсэн бөгөөд энэ бүхнийг үнэн гэдгийг мэдсэн юм.

Хэдий тийм ч, би өмнөхөөсөө ч их эсэргүүцэл, няцаалттай тулгарч байлаа. Би ганцаардаж, ядарч мөн эргэлзэж байв. Хэрэв би зөв зүйл хийж байгаа бол яагаад ийм их саадтай тулгарна вэ? Бэрхшээлүүд маань хэрхэн миний сайн сайхны төлөө байх билээ гэдгийг би ойлгохгүй байлаа. Номлогчид надад хичээлтэй өдөр байсан ч хамаагүй мацаг барьж, залбирах ёстойг заалаа. Хэдийгээр юмс тэсвэрлэхийн аргагүй болж байсан ч би зүрх сэтгэлээсээ залбиран, тэр даруй Сүнсний тайтгарлыг мэдэрсэн юм.

Баптисм хүртсэн долоо хоног маань бэрхшээлээр дүүрэн байсан. Баптисм хүртэх өдөр дарга маань өөр хэн нэгнээр ажлаа хийлгэх юм бол хална гэж сүрдүүлж мөн бөөрний чулуутайн улмаас эмнэлэгт хэвтэх болж, бүр эцэг эх маань хүртэл намайг гэрээсээ явахыг шаардаж байлаа. Олон зүйлийг хянах чадваргүй болсон тэр үед миний хийж чадах ганцхан зүйл Их Эзэнд хандах байсан юм.

Тэр бүх сорилт эцэст нь миний тусын тулд болсон байлаа. Эдгээр бэрхшээл нь надад сайн мэдээний сургаалаас суралцахад тусалж, түүнчлэн гэрчлэлийн маань үндэс суурь болсон билээ.

*Өгүүлэгч нь АНУ-ын Айдаход амьдардаг.*



## Гэрлэлт Бурханаас томилогдсон

*Энэ материалыг залбирч судлан, хуваалцах зүйлээ мэдэхийн тулд эрэлхийлж хай. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-ийг ойлгох нь Бурханд итгэх итгэлийг тань хэрхэн нэмэгдүүлж мөн харж ханддаг хүмүүсийн тань амьдралыг айлчлагч багшаар дамжуулан хэрхэн адисалж болох вэ? Дэлгэрэнгүй мэдээлэл авах бол [reliefsociety.lds.org](http://reliefsociety.lds.org) хаягаар орж үзнэ үү.*

Итгэл, гэр бүл, халамж

**Б**ошиглогч, төлөөлөгч, удирдагчид “эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлтийг Бурхан заяасан бөгөөд гэр бүл нь Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдаг”<sup>1</sup> гэдгийг тунхагласаар ирсэн.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Д.Тодд Кристоффэрсон: “Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гэрлэлт дээр үндэслэгдсэн гэр бүл Бурханы төлөвлөгөө амжилттай хэрэгжих орчинг бүрдүүлдэг. . . .

. . . Бид эсвэл өөр ямар ч мөнх бус хүн гэрлэлтийн энэхүү тэнгэрлэг жаягийг өөрчилж болохгүй”<sup>2</sup> гэж хэлжээ.

Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч Бонни Л.Оскарсон: “Гэр бүлийн нөхцөл байдал ямар болох мөн хэдэн хүүхэдтэй гэдгээсээ үл хамаараад хүн бүр гэр бүлийн тунхагт тайлбарласан Их Эзэний төлөвлөгөөний хамгаалагч нь байж чадна. Хэрэв энэ нь Их Эзэний төлөвлөгөө юм бол мөн бидний ч төлөвлөгөө байх ёстой!”<sup>3</sup> гэжээ.

Ахлагч Кристоффэрсон цааш нь: “Та нарын зарим нь сэтгэлд нийцсэн хүн олдохгүй байх, ижил хүйстэндээ татагдах байдал, бие махбодын болоод сэтгэл санааны

хөгжлийн бэрхшээл эсвэл бүтэлгүйтнэ гэсэн айдас зэрэг шалтгаануудаас болоод гэрлэлтийн адислал авч чадаагүй байгаа. Эсвэл та нар гэрлэсэн боловч гэрлэлт тань салалтаар дууссан байж болно. Та нарын зарим нь гэрлэсэн боловч . . . хүүхэдтэй болж чадахгүй байгаа. . . .

Гэхдээ . . . хүн бүр аль ч үед тэнгэрлэг төлөвлөгөөг биелүүлдэг хувь нэмрээ оруулж чадна”<sup>4</sup> гэж хэлсэн билээ.

### Нэмэлт судрууд

Эхлэл 2:18–24; 1 Коринт 11:11; Сургаал ба Гэрээ 49:15–17

### Бодит түүх

Залуу эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх асан Ларри М.Гибсон ах эхнэр Шэрлигийнхээ хэлсэн дараах үгийг санан,

“Чи надаас илүү Бурханд хайртай байдаг болохоор би чамд хайртай’ . . . гэж хэлсэн түүний минь хариулт миний зүрхийг догдуулсан ба . . .

намайг Их Эзэнд бүхнээс илүү хайртайг тэр үргэлж мэдрээсэй гэж би хүссэн”<sup>5</sup> гэж хэлжээ.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Дэвид А.Бэднар: “Их Эзэн Есүс Христ бол гэрээний гэрлэлтийн гол цөм юм. . . . Аврагч бол гурвалжингийн орой, эмэгтэй хүн суурийн нэг өнцөг, харин эрэгтэй хүн нөгөө өнцөг нь хэмээн төсөөлөөд үз. Тэгвэл эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын харилцаанд тэд ‘Христэд ирж’, ‘Түүгээр төгөлдөржихөд’ (Моронай 10:32) юу тохиолдохыг эргэцүүлэн бод. Гэтэлгэгчийн ачаар мөн Гэтэлгэгчээр дамжуулан эрэгтэй, эмэгтэй хүмүүс нэг нэгэндээ илүү ойртдог” гэж заасан юм.

### Эшлэл

1. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Лиакхона*, 2010 оны 11-р сар, 129.
2. Д.Тодд Кристоффэрсон, “Гэрлэж, гэр бүлтэй болох шалтгаан,” *2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 35.
3. Бонни Л.Оскарсон, “Гэр бүлийн тунхгийн хамгаалагчид,” *2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 132.
4. Д.Тодд Кристоффэрсон, “Гэрлэж, гэр бүлтэй болох шалтгаан,” 35.
5. Ларри М.Гибсон, “Fulfilling Our Eternal Destiny,” *Ensign*, 2015 оны 2-р сар, 21–22.
6. Дэвид А.Бэднар, “Marriage Is Essential to His Eternal Plan,” *Ensign*, 2006 оны 6-р сар, 54.

### Үүнийг эргэцүүлэн бод

Би “Христэд ирэхээр” хэрхэн бие даан мөн тасралтгүй хичээх вэ?